



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 342

Улаанбаатар хот

### Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2017 он, 2018 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар тус үйлдвэрийн газар нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 20 дугаар зүйлийн 20.5, 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт заасныг тус тус зөрчин байгууллагад хэрэгцээ шаардлагагүй 111.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч, 68.7 сая төгрөгийн хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр балансаас балансад шилжүүлэн, байгууллагад 108.3 сая төгрөгийн хохирол учруулсан, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 8 дугаар тогтоолын 2.2 дахь хэсэгт заасныг зөрчин Эрчим хүчний яамны 299.2 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 14-16 дугаар зүйлд заасныг тус тус зөрчин 209.7 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулж явуулсан зэрэг нийт 644.5 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирал М.Түмэнжаргалд дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажиллаж хүрээлэнгийн үйл ажиллагаанд шаардлагагүй хөрөнгө оруулалт хийх, шилжүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг таслан зогсоох;

2.3. Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн төрийн өмчит үйлдвэрийн газрын нэр дээр бүртгэлтэй 108 м<sup>2</sup> конторын зориулалттай газрыг /хуучнаар/ Төрийн өмчийн хорооны 2011 оны 52 дугаар тогтоолын 2 дахь заалтыг үндэслэн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх;

2.4. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 8 дугаар тогтоолын 2.2 дахь хэсэгт “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дээд шатны байгууллага, төрийн захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлэхийг

000071

зогсоох, зөрчсөн албан тушаалтанд хуулийн хүрээнд арга хэмжээ авч байх" гэж заасныг мөрдөн ажиллах;

2.5. Худалдан авах ажиллагаанд "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль", Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан "Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайллагнах журам"-ыг мөрдөн ажиллах;

2.6. Байгууллагын санхүүгийн тайланда бүртгэлтэй, 1 жил ба түүнээс дээш хугацаатай авлагыг барагдуулах, шаардлагатай бол хууль хяналтын байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу найдваргүй авлагын нөөц байгуулах, энэ талаар холбогдох баримт бичигт тусгах, цаашид найдваргүй авлага үүсгэхгүй ажиллах;

2.7. Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, мөнгөн кассын үйл ажиллагааны журам боловсруулж мөрдөн ажиллах, бэлэн мөнгөний гүйлгээг багасгах, анхан шатны баримтгүй ажил гүйлгээ хийх, данс бүртгэлд тусгахгүй байх;

2.8. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн ажиллах журам боловсруулж, зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, өмчид бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

2.9. Байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тушаалаар баталсан журмын хэрэгжилтийг ханган ажиллах;

2.10. Ажлын байрны тодорхойлолтыг ажил эрхлэгчид тохируулах бус, тухайн байгууллагын зорилт, чиг үүргийг үр ашиг, үр нөлөөтэй хэрэгжүүлэх шаардлагад нийцүүлэн үр дүнд тулгуурлан боловсруулж түүнд нийцүүлэн ажилтныг сонгон шалгаруулж авах.

3. Шалгалтын тайланда дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЭРДЭНЭБАЯР

Төрийн өмчийн бөдлого, зохицуулалтын газрын  
2019 оны 8 дугаар сарын 19-ны өдрийн  
8 дугаар тогтоолын хавсралт

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГТ ХИЙСЭН  
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг  
арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах нэгж	Мөнгөн дүн /сая төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, үндэслэл	Захиргаа удирдлагын алба	42.4	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.5 дахь хэсэгт заасныг мөрдөн ажиллах.
2	Төрийн өмчийн эд хөрөнгийн захиран зарцуулалт	Захиргаа удирдлагын алба	68.7	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30.3, 31.1 дэх хэсэгт заасныг мөрдөн ажиллах.
3	Дээд байгууллагын зардлыг санхүүжүүлсэн	Захиргаа удирдлагын алба	299.2	“Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 8 дугаар тогтоолыг мөрдөн ажиллах.
4	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны зөрчил	Захиргаа удирдлагын алба	209.7	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хууль, холбогдох журмыг мөрдөж ажиллах.
5	Анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээ	Захиргаа удирдлагын алба	24.5	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөн ажиллах, дараа тайлангаар авсан томилолтын тооцоог хаагаагүй ажилтнуудтай хариуцлага тооцох. Энэ талаар холбогдох яам, байгууллагад тухай бүр албан бичгээр мэдээлэл хүргүүлж шаардлагатай арга хэмжээг авахуулах.
6	Газар эзэмших эрхийн бүртгэл, баталгаажилт	Захиргаа удирдлагын алба	108 м <sup>2</sup>	Төрийн өмчийн хорооны 2011 оны 52 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт заасны дагуу Газар эзэмших эрхийг эд хөрөнгийн эрхийн Улсын бүртгэлд бүртгүүлж баталгаажуулах.
НИЙТ ДҮН:			644.5	